



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/15

Баянгол

Зээл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4.5 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 08 дугаар тогтоол, Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад дурдсан 3 иргэн, 1 аж ахуйн нэгжид журмын дагуу зээл олгохыг санхүүгийн албаны дарга /Н.Гэрэлмаа/, ня-бо /Л.Оюунбилэг/ нарт зөвшөөрсүгэй.

2. Зээл авсан иргэд, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэхийг /Х.Төртулга/, төслийн явц, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг /Н.Ганзориг/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700033

Сумын Засаг даргын 20.03 оны 03  
дугаар сарын 12-ны өдрийн 4/15  
дугаар захирамжийн хавсралт

№	Төслийн нэр	Төсөл санаачлагч	Санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн зээлийн хэмжээ
1.	“Бизнес төлөвлөгөө” төсөл	“Тунгалаг рашаант ХХК” Г.Сайнхүү	15 сая
2.	“Сүлжмэл ааруул” төсөл	Д.Болдбаатар	10 сая
3.	“Тохилог орчин” төсөл	Л.Эрдэнэбаатар	3 сая
4.	“Хэрчсэн гурил” төсөл	П.Долгормаа	3 сая
	Нийт дүн		31 сая



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/16

Баянгол

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.3 дахь заалт, Аймгийн засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/363 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн дотуур байрны сурагчдын хоол хүнс болон үдийн цайны хүнсний бүтээгдэхүүн, Цэцэрлэгийн хүүхдийн хоол цайны бүтээгдэхүүн нийлүүлэх тендер шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Гэрэлмаа /Санхүүгийн албаны дарга/

Нарийн бичгийн дарга: Д.Ончимэг /ДАШБХ мэргэжилтэн/

Гишүүд: Д.Эрдэнэтуяа /Сургуулийн эмч/

Ө.Гансүх / Сургалтын менежер /

Д.Алтайбаатар /Сургууль, цэцэрлэгийн ня-бо /

Д.Ганзул /Эцэг эхийн төлөөлөл/

Б.Баярмаа / Эцэг эхийн төлөөлөл/

В.Оролмаа /Цэцэрлэгийн нярав/

Г.Ариунаа /Сургуулийн нярав /

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу ил тод, нээлттэй шалгаруулж, зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700037



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ШАРГА СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

20 18 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/17

Баянгол

Үрчлэлт бүртгэх тухай

Гэр бүлийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.7 дахь заалтыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шарга сумын Сондуулт багийн иргэн Хойд овогтой Ложоохүүгийн Батхүү,  
Таадгар овогтой Норонгийн Энхцэцэг нарын хүсэлтийг үндэслэн тус сумын  
Сондуулт багийн иргэн Хойд овогтой Довжидмаагийн Ариунболорыг Хойд овогтой  
Ложоохүүгийн Батхүүд үрчлүүлэхийг хүлээн зөвшөөрсүгэй.

2. Холбогдох баримтыг бүрдүүлж аймгийн Оюуны өмч, Улсын бүртгэлийн  
хэлтсийн Иргэний бүртгэл мэдээллийн тасагт хүргүүлэхийг Улсын бүртгэгч  
/Г.Гантулга/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ТУНГАЛАГТАМИР

C/barimt/Zahiramj/2018

00700039